



ШУВУУНЫ ТОМУУ ӨВЧНИЙ ТОХИОЛДОЛ ТАРХАЛТЫН ХОЁР ДОЛОО ХОНОГ ТУТМЫН МЭДЭЭ №07

Нэг. Монгол оронд бүртгэгдсэн шувууны томуугийн сэжигтэй тохиолдол

2023 оны 03-р сарын 17 ноос 04-р сарын 14 ний хооронд шувууны томуугийн холбогдолтой өвчлөлийн сэжигтэй тохиолдол бүртгэгдээгүй.

Шувууны томуугийн улиралчлал эхэлж байгаатай холбогдуулан урьдчилан сэргийлэх зөвлөгөө, зөвлөмжийг доор хавсаргав.

Хоёр. Дэлхий дахинд бүртгэгдсэн шувууны томуугийн хүний өвчлөл

2023 оны 03-р сарын 17 ноос 04-р сарын 14 ний хооронд шувууны томуугийн А хүрээний H7N9, H9N2, H6N1, H10N8, H7N4, H5N6, H5N8, H10N3 вирусийн хүний өвчлөлийн шинэ тохиолдол бүртгэгдээгүй байна.

Шувууны томуугийн А хүрээний H3N8 вирусийн халдвар

БНХАУ-ын Гуандон мужид 56 настай, эмэгтэйд 2-р сарын 22-нд бие хямрах шинж тэмдэг илэрч, улмаар 3-р сарын 3-нд уушгины хатгалгааны улмаас эмнэлэгт хэвтэж, 3-р сарын 16-нд нас барсан тухай мэдээлжээ. Лабораторийн шинжилгээгээр шувууны томуугийн А хүрээний H3N8 вирусийн халдвар илэрсэн. Тархвар судлалын холбогдлын хувьд халдвар авахаасаа өмнө шувуудтай харьцаж байсан. Гэрийнх нь ойролцоо зэрлэг шувууд байдаг өгүүлэмжтэй.

Сул хоруу H3N8 дэд хэвшинжийн вирус нь 1889-1900 оны үед ЗХУ-д цар тахлын хэмжээнд хүрч байсан гэж үздэг. Үүнээс хойш нүүдлийн шувуудад хамгийн өргөн тархсан. 1962 оны үед анх адуунд, 10 жилийн дараагаас махчин амьтдад, 2016 оноос гэрийн тэжээвэр амьтдад бүртгэгдэж байсан.

Чили улсын ЭМЯамаас 03-р сарны 30-нд H5N1 вирусээр 53 настай иргэн өвчилсөн болохыг мэдээллээ. Халдварын эх уурхайг тогтоохоор ажиллаж байгаа ба одоогоор өөр сэжигтэй тохиолдол бүртгэгдээгүй байна. Хүнээс хүнд халдвар дамжсан тохиолдол одоогоор бүртгэгдээгүй байна.

Эх сурвалж: <https://www.who.int/emergencies/disease-outbreak-news/item/2023-DON456>

Гурав. Дэлхий дахинд бүртгэгдсэн шувууны томуугийн А хүрээний вирусээр өвчилсөн амьтдын мэдээлэл:

2023 оны 03-р сарын 17 ноос 04-р сарын 14 ний хооронд шувууны томуугийн А хүрээний вирус Аргентин, Австри, Белги, Болив, Чили, Болгар, Канад, Колумб, Чех, Дани, Франц, Гамби, Герман, Унгар, Индонез, Ирланд, Итали, Япон, Латви, Непал, Голланд, Польш, Өмнөд Солонгос, ОХУ, Румин, Синегал, Серби, Словени, Испани, Швед, Швейцар, Тайвань, Их Британи, Уругвай, АНУ зэрэг 35 улс орны газар нутагт нүүдлийн болон тэжээвэр шувуудын дунд 105 тохиолдол бүртгэгдсэн (Дэлгэрэнгүй мэдээллийг хүснэгт 1, зураг 1 ээс харна уу). Хун, галуу, нугас, тогоруу, шонхор, цахлай зэрэг нүүдлийн усны, махчин 31 зүйлийн шувуу, хөхтөн амьтны 4 зүйлд өвчлөл бүртгэгдсэн.


Хүснэгт 1. Шувууны томуугийн А хүрээний вирусийн хэв шинжээр тархалт

Дэд хэвшинж	Улс	Зүйлийн нэр	Нийт тохиолдол
H5	Аргентин	Нугас, тахианы аж ахуй	23
H5N1	Австри	Цахлай, шонхор, сар шувуу	25
H5N1	Белги	Зэрлэг шувууд, үнэг	18
H5N1	Болив	Нугас, тахианы аж ахуй	22
H5, H5N1	Чили	Хун, тахианы аж ахуй, Далайн арслан <i>Otaria flavescens</i>	25
H5N1	Болгар	Тахианы аж ахуй	1
H5N1	Канад	Тахианы аж ахуй	4
H5N1	Колумб	Тахианы аж ахуй, хотон	6
H5, H5N1	Чех	Хун, тахианы аж ахуй	4
H5N1	Дани	Тахианы аж ахуй	1
H5N1	Франц	Хүрэн толгойт цахлай, Тахианы аж ахуй	34
H5N1	Гамби	Цахлай	1
H5N1	Герман	Тахианы аж ахуй, хотон, цахлай, нугасны төрлийн шувууд	43
H5N1	Унгар	Гунгар хун, тахианы аж ахуй	43
-	Индонез	Тахианы аж ахуй	4
H5N1	Ирланд	Цахлай, хараалай	2
H5N1	Итали	Цахлай /2-3 зүйл/, Дэглий, Эгэл шонхор, тагтаа	72
H5N1	Япон	Тахианы аж ахуй	8
H5N1	Латви	Хүрэн толгойт цахлай	1
H5N1	Непал	Тахианы аж ахуй	2
H5N1	Голланд	Цахлай /2-3 зүйл/, Дэглий, Эгэл шонхор, тагтаа, хэрээ, галуу /2-3 зүйл/,	155

		хун	
H5N1	Польш	Хараалай, цахлай, гунгар хун	9
H5N1	Өмнөд Солонгос	Тахианы аж ахуй	10
H5N1	ОХУ	Хотон, Цахлай	2
H5N1	Румин	Гунгар хун	
H5N1	Синегал	Тахианы аж ахуй	1
H5N1	Серби	Тахианы аж ахуй	2
H5N1	Словени	Хээрийн бор шувуу, сар шувуу, гунгар хун	4
H5N1	Испани	Шар шувуу, цахлай	5
H5N1	Швед	Галуу /2-3 зүйл/	5
	Швейцар	Хар өрөвтас, гунгар хун, шунгуур, цахлай /2-3 зүйл/	32
H5N1	Тайвань	Тахианы аж ахуй, хараалай	10
H5N1	Их Британи	Хун, цахлай /2-3 зүйл/	9
H5	Уругвай	Тахианы аж ахуй	3
H5N1	АНУ	Муур, нохой, үнэг, пума, Skunk <i>Mephitis mephitis</i> , Тахианы аж ахуй	19

Эх сурвалж: <https://empres-i.apps.fao.org/>

Зураг 1. 2023 оны 03-р сарын 17 ноос 04-р сарын 14 ний хооронд шувуудын дунд бүртгэгдсэн шувууны томуугийн А хүрээний вирусийн тохиолдлын тархалт



УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

Шувууны аж ахуй эрхлэгчид:

- Гадаад орчноос халдвар дамжин ирэх эрсдэлийг бууруулах зорилгоор зайлшгүй нэврэх ажилчид, техник хэрэгслийн жагсаалт гаргаж, нэвтрүүлэх
- Халдвар хамгааллын дэглэм мөрдөх буюу шувууны байранд орох болон гарахдаа гутлаа тогтмол цэвэрлэх, гараа тогтмол савандаж угаах, техник хэрэгслийн дугуйг халдваргүйжүүлэх
- Шувуудыг нүүдлийн шувууд болон төв суурин газрын бусад шувуудаас тусгаарлах
- Тэжээвэр шувууг худалдан авах, зарахдаа анхааралтай болгоомжтой хандах
- Шувууны гаралтай түүхий эдийг хагас боловсруулсан байдлаар хэрэглэхгүй байх

Шувууны аж ахуйд өвчний сэжигтэй, өвчилсөн шувууд бүртгэгдсэн үед:

- ЗӨСҮТ-н 70282853 дугаарт мэдээлэл өгөх
- Шувууны аж ахуйн орчинд нэвтрэх хүний болон техник хэрэгсэлийн хөдөлгөөнийг хязгаарлах, бүртгэл хөтлөх
- Төмөр тор, тоног төхөөрөмж, байрны бетон шал болон шалны хөндлөвч, хог зайлуулах суваг, шувууны суултуур, тэжээлийн сав, услууур зэрэгт халдваргүйжүүлэлтийг холбогдох зааврын дагуу хийх
- Өвчний сэжигтэй шувуудыг бусад шувуудаас тусгаарлах, мэрэгч амьтад орж гарах нүхийг битүүлэх
- Ханиадны шинж тэмдэг хүнд илрэвэл маск зүүж, эмнэлэгт хандах

Малчид, ард иргэдэд:

- Сэжигтэй /өвчилсөн, үхсэн/ шувуудад ойртохгүй байх, мэдээлэх
- Гол, нуурын эргээр техник хэрэгслээр явсан тохиолдолд гэрээс хол зогсоолд байршуулах, гуталны улыг арчиж гэртээ орох
- Шувууд олноор эндсэн нуурын усыг ахуйн хэрэгцээнд хэрэглэхгүй байх


ЗӨСҮТ- Шувууны томуу хариуцсан баг



Эрүүл харагдах шувууд ч шувууны томуу өвчнийг дамжуулах эрсдэлтэй

Халдвар дамжих зам

(ЭРСДЭЛ БАГА БОЛОВЧ УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЖ, АМНЫ ХААЛТ ЗҮҮН, ГАРАА ТОГТМОЛ УГААЖ БАЙХ
ШААРЛАГАТАЙ)





Шувууны томуу



Халдвар дамжих зам

(Хүн шувууны томуу өвчний халдвард өртөх эрсдэл бага боловч урьдчилан сэргийлж, амны хаалт зүүн, гараа тогтмол угааж байх шаардлагатай)




1 Шууд хавьтал



2 Халдвартай хөрс шороо



3 Агаар дусал



Урьдчилан сэргийлэх арга хэмжээ

